## ӨМНӨГОВЬ АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН 2025 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БҮТЭН ЖИЛИЙН БИЕЛЭЛТ

2025.12.15

| № | Зорилт, арга хэмжээнүүд | Хэмжих нэгж, шалгуур үзүүлэлт | Хүрэх түвшин, үр дүн | Хариуцах албан тушаалтан | Биелэлт (%) | Зарцуулсан төсөв /сая.төг/ | Хөрөнгийн эх үүсвэр | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Даланзадгад суманд тэмээний тэрэлжсэн мал эмнэлгийн барилгыг барьж ашиглалтад оруулах | Хувь | 100 | ХХААГ | 100 | 603.6 | ОНТ | 2024 онд "Тэмээ судлалын төв, тэмээний тэрэлжсэн мал эмнэлэг"-ийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажлыг "Урбан виши" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж, батлагдсан ТЭЗҮ, зураг төсвийн дагуу 2024-2025 онд "Даланзадгад суманд тэмээний тэрэлжсэн мал эмнэлгийн барилга барьж ашиглалтад оруулах" ажлыг "Бадрахмандал шим" ХХК-тай 2,571,030,203 төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулан гүйцэтгүүлж ашиглалтад хүлээн авсан. /2024 оны санхүүжилт 492.5 сая/ Тус тэмээ судлалын төв, тэмээний тэрэлжсэн мал эмнэлэг"-ийн барилгын нэмэлт ажлын 110.8 сая төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулан гүйцэтгүүлж ашиглалтад хүлээн авсан. |
| 2 | Тэмээний тэрэлжсэн мал эмнэлэг, тэмээ судлалын төвийг оффисын тавилга, тоног төхөөрөмжөөр хангах | Хувь | 100 | ХХААГ | 100 | 43.5 | ОНТ | Тэмээний тэрэлжсэн мал эмнэлэг, тэмээ судлалын төвд шаардлагатай оффисын тавилга,тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг "Монтех дистрибьюшн" ХХК-тай байгуулан гүйцэтгүүлж, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн. Мөн "Тэмээ судлалын төвийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах тоног төхөөрөмж нийлүүлэх, суурилуулах" ажлыг Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн 1,009,735.0 сая төгрөгийн санхүүжилтээр гэрээ байгуулан гүйцэтгүүлж ашиглагч байгууллагад хүлээлгэн өгсөн |
| 3 | "Хүнсний хангамж - аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд Даланзадгад сумын хүн амын хавар зуны улирлын хэрэгцээг хангах зорилгоор хөнгөлөлттэй үнээр мах худалдах ажлыг зохион байгуулах, махны нөөц бүрдүүлэх | тн | 200 | ХХААГ | 100 | 405 | ОНТ | Даланзадгад сумын хүн амын хавар, зуны улирлын махны хэрэгцээг хангах, үнийн хөөрөгдөл үүсгэхгүй байх, махны үнийг тогтворжуулах зорилгоор махны нөөц бүрдүүлэх ажлыг "Их нуттийн хаяа" ХХК-тай гэрээ байгуулан 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд 130 тонн (үхрийн мах-26 тонн, ямааны мах-65 тонн, хонины мах-39 тонн) махны нөөц бүрдүүлсэн. 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхэлж, 06 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд хөнгөлөлттэй үнээр (килограмм тутам үхрийн мах 10500, хонины мах 8500, ямааны мах 7500 төгрөг) Даланзадгад сумын иргэдэд 10 багийн 14 цэг дэлгүүрээр жижиглэнгээр худалдан борлуулж ажилласан. Даланзадгад сумын 2026 оны хавар, зуны улирлын 200 тн махны нөөцийг бүрдүүлэх төслийн материалыг хянах шатанд явж байна |
| 4 | "Хүнсний хангамж - аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд Гашуун сухайтын хилийн боомтод хорио цээрийн лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх | Хувь | 100 | ХХААГ | 100 | 267.3 | ОНТ | Гашуун сухайтын хилийн боомтод хүнсний бүтээгдэхүүний сорил, шинжилгээний болон хорио цээрийн лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг "Төгс гал шицэ" ХХК-тай 267,268,700 төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулан гүйцэтгүүлж Гашуунсухайт боомтын захиргаанд хүлээлгэн өгсөн. |
| 5 | "Хүнсний хангамж - аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд төмс, хүнсний ногооны 500 тонны багтаамжтай механикжсан зоорийг барьж ашиглалтад оруулах /хөргүүрийн систем/ | Хувь | 100 | ХХААГ | 100 | 733.52 | ОНТ | Хүнсний хангамж - аюулгүй байдал үндэсний хөдөлгөөний хүрээнд төмс, хүнсний ногооны 500 тонны багтаамжтай механикжсан зоорийг барьж ашиглалтад оруулах ажлын хүрээнд хөргүүрийн систем угсарч суурилуулах, тоноглох ажлыг "Том илч" ХХК-тай 723,364,823 төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. Гэрээт ажлыг 10 сарын 15-ныг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэн ашиглалтад оруулна. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 6 | "Хүнсний хангамж - аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд Цогт-Овоо суманд мал нядалгааны газар байгуулах | Хувь | 100 | ХХААГ | 100 | 546.5 | ОНТ | "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд Цогт-Овоо суманд мал нядалгааны газар байгуулах ажлын худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу батлагдсан төсвийн хүрээнд зохион байгуулан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан гүйцэтгүүлэхийг Цогт-Овоо сумын Засаг даргын Тамгын газарт аймгийн Засаг даргын 2025 оны А/459 тоот захирамжаар эрх шилжүүлсэн. Үүний дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж "Арвин эрдэнэ" ХХК-тай 546.5 сая төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулан гүйцэтгүүлж барилгын ажлыг ашиглалтад хүлээн авсан. |
| 7 | "Чинээлэг малчин" хөтөлбөрийн хүрээнд удам залгасан малчдад гэр олгох, сургалт зохион байгуулах | Хувь | 30 | ХХААГ | 100 | 167.7 | ОНТ | Удам залгасан малчдад олгох 35 ширхэг, 5 ханатай иж бүрэн монгол гэр нийлүүлэх ажлыг "Дэвжих үед" ХХК-тай 167,650,00 төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулан гүйцэтгүүлж, ашиглалтад хүлээн авсан. "Удам залгасан залуу малчин өрхийг дэмжих журам"-ын дагуу 2024 онд удам залган өрх тусгаарласан 30 малчин өрхийн 60 залуу малчдад 1 өдрийн танхимын сургалт зохион байгуулж, 5 ханатай Монгол гэрийн дэмжлэгийг гардуулж ажилласан. |
| 8 | "Чинээлэг малчин" хөтөлбөрийн хүрээнд Ботгоны мөнгөн урамшуулал олгох | Хувь | 100 | ХХААГ | 100 | 157.1 | ОНТ | Хоёр бөхт тэмээний генефондыг хамгаалан, өсгөн үржүүлж байгаа малчдын хөдөлмөрийг бодит урамшуулах зорилгоор "Ботгоны мөнгөн урамшуулал олгох журам"-ыг шинэчлэн батлуулж, 2024 онд ботго бойжуулсан 15 сумын 2010 малчин өрхөд 157,1 сая төгрөгийн мөнгөн урамшууллыг олгосон. |
| 9 | "Чинээлэг малчин" хөтөлбөрийн хүрээнд дутагдалтай бог малын хээлтүүлэгч нөхөж тавих | Хувь | 100 | ХХААГ | 100 | 59.5 | ОНТ | Дутагдалтай бог малын хээлтүүлэгч нөхөх ажлыг орон нутгийн батлагдсан үүлдэр, омгийн мал сүргийн 370 толгой өсвөр хээлтүүлэгчээр нөхөж, үржилд ашиглахаар төлөвлөсний дагуу Гавилууд омгийн хонины 200 толгой, Цогт-Овоогийн улаан омгийн ямааны 170 толгой өсвөр хээлтүүлэгч нийлүүлэх ажлыг 2 багц болгох худалдан авах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулсан. Цогт-Овоогийн улаан омгийн ямааны 170 толгой өсвөр хээлтүүлэгч нийлүүлэх /Багц-2/ ажлыг "Шүтээн аглага трейд" ХХК-тай 59,5 сая төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулан гүйцэтгүүлж, 15 сумын 170 малчин өрхөд олгож бог малын хээлтүүлэгчийн хуралцээ хангамжийг нэмэгдүүлсэн. Гавилууд омгийн хонины 200 толгой өсвөр хээлтүүлэгч нийлүүлэх /Багц-1/ ажлын гүйцэтгэгч шалгараагүй тул тухайн онд хэрэгжээгүй. |
| 10 | "Чинээлэг малчин" хөтөлбөрийн хүрээнд Нутгийн шилмэл сүрэгт шинжлэх ухааны судалгаа үргэлжлүүлэх /Зурамтайн цагаан ямаа, Говь шанхын адуу/ | Хувь | 70 | ХХААГ | 100 | 17.0 | ОНТ | Орон нутгийн шилмэл сүрэг болох Зурамтайн цагаан ямааны аж ахуй, биологийн онцлог, ашиг шимийн үндсэн үзүүлэлтийг тогтоох судалгаа, шинжилгээний ажилд шаардагдах 17,035,000 төгрөгийг шийдвэрлэн аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт шилжүүлсэн. Зурамтайн цагаан ямааг өсгөн үржүүлдэг цөм сүргийн хавар намрын ангилалтанд давхардсан тоогоор 40 өрхөөр орж 5500 ямаанд ангилалт хийж үүнээс 600 ямаанаас биеийн үндсэн хэмжээс авч, 160 эзэмжүүлэн бүртгэж, Тус ямааны генетикийн шинжилгээ нь БНХАУ-д хийлгэж ГГСайхан үүлдрийн ямааны цус сэлбээгүй болохыг мэргэжлийн лаборатори дүн шинжилгээ ирсэн. Энэ жилийн Зурамтайн цагаан ямааны судалгааны ажил бүрэн хийгдэж дууссан. Цаашид 2026 онд хянан магадлагааны ажлын хэсгийг ажиллуулахаар төлөвлөсөн.<br>Говь шанхын адууг омог болгон батлуулах ажлын хүрээнд МААЭШХүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн хурлаар оруулж дэмжигдсэн. Говь шанхын адууны цөм сүргийн 40 өрхийн 400 толгой хээлтэгчийг чип зүүж бүртгэлжүүлсэн. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар батлагдсан 7 хүний бүрэлдэхүүнтэй хянан магадлагааны ажлын хэсгийг гишүүд Говь шанхын адууны намрын хянан магадлагаанд ажиллаж зөвлөмжийг хүргүүлэхээр болсон. Намрын хянан магадлагааны ажлын хэсгийн гишүүд 3 адуунд нядлагын гарц тодорхойлж 120 толгой адуунаас биеийн үндсэн үзүүлэлтийн хэмжээг авсан. |
| 11 | "Чинээлэг малчин" хөтөлбөрийн хүрээнд малчдын зөвлөгөөн зохион байгуулах | Хувь | 100 | ХХААГ | | | | "Чинээлэг малчин өрх" хөтөлбөрийн хүрээнд 2 жил тутамд 1 удаа зохион байгуулагддаг малчдын зөвлөгөөнийг 4 дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл хангаж ажилласан боловч цаг үеийн нөхцөл байдал, шатахууны хомтлоос шалтгаалан уг арга хэмжээг 2026 онд зохион байгуулахаар хойшлуулан 2026 оны төлөвлөлтөд тусгасан. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | "Чинээлэг малчин" хөтөлбөрийн хүрээнд малчдын хөдөлмөр хөнгөвчлөх технологи нэвтрүүлэх | Хувь | 100 | ХХААГ | 100 | 50 | ОНТ | Тайланд онд тэмээ зогсоогоор хяргах, ноослох тоноглол, ингэ саах цахилгаан саалтуур нийлүүлэх технологи нэвтрүүлж, малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөхөөр төлөвлөсөн. Үүний дагуу тэмээ зогсоогоор хяргах, ноослох тоноглол нийлүүлэх /Багц-1/, ингэ саах цахилгаан саалтуур нийлүүлэх /Багц-2/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хуулийн дагуу зохион байгуулж "Ингэ саах цахилгаан саалтуур" нийлүүлэх /Багц-2/" ажлыг "Авид намгүр, инженеринг" ХХК-тай 49,980,000 төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулан гүйцэтгүүлж хүлээн авсан. Үүний дагуу малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх, малын сүү цагаан идээг боловсруулах технологийг өрхийн үйлдвэрлэлд нэвтрүүлэхээр 15 сумын 21 малчин өрхийн малчдад ингэ саах цахилгаан саалтуурыг ашиглах, цахилгаан саалтуурт ингэ сургах сургалтыг зохион байгуулж, цахилгаан саалтуур олголоо. Тэмээ зогсоогоор хяргах, ноослох тоноглол нийлүүлэх /Багц-1/ ажлын гүйцэтгэгч шалгараагүй тул тухайн онд хэрэгжээгүй байна. |
| 13 | "Чинээлэг малчин" хөтөлбөрийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах | Хувь | 90 | ХХААГ | 100 | | ОНТ | Орон нутгийн байгаль орчин, газар зүйн онцлогт тохируулан, малын үүлдэр угсааг сайжруулах, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, малчин өрхийг орон нутагтаа чинээлэг амьдрах боломжийг бүрдүүлэх зорилго бүхий "Чинээлэг малчин өрх" хөтөлбөрийг боловсруулан аймгийн ИТХ-ын 2025 оны 4/13 дугаар тогтоолоор батлуулан, 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>-15 сумын 30 малчин өрхийн 60 залуу малчдад 1 өдрийн танхимын сургалт зохион байгуулсан.<br>-Ингэ саах цахилгаан саалтуурыг ашиглах, цахилгаан саалтуурт ингэ сургах сургалтыг 15 сумын 21 малчинд зохион байгуулсан. 9 сум тус цахилгаан саалтуурыг туршилтаар ашиглаж эхэлсэн, малчдын хөдөлмөрийг хөнгөвчилсөн ажил болсон тул уг арга хэмжээг цаашид үргэлжлүүлэх саналтай байна.<br>-Төв аймагт зохион байгуулагдсан Алтан хэйч-2025 хонь хяргах улсын уралдаанд 2 малчныг оролцуулж 1 малчин пеналд шалгарсан.<br>-Дархан уул аймгийн Хонгор суманд зохион байгуулагдсан улсын Шилмэл мал-2025 арга хэмжээнд Цогт-Овоо сумаас 4 малчин Галбын говийн улаан үүлдрийн 1 буур, Ханын хэцийн хүрэн үүлдрийн 1 ингэ, Цогт-Овоогийн улаан омгийн 1 ухна, 2 эм ямаа, Монгол үүлдрийн 1 эм хоньтой амжилттай оролцсон.<br>- Дундговь аймагт зохион байгуулагдсан Цогжилттэй тэмцэхэд залуусын оролцоо үндэсний форумд Гурвантэс, Ханхонгор сумын 3 залуу малчныг оролцуулсан.<br>-БНХАУ-н ӨМӨЗО-ны Шилийн гол аймагт зохион байгуулагдсан Монгол малчин-2025 сургалтад 11 сумын 13 малчныг 7 хоногийн хугацаанд хамруулж сургалтаар ШУ-нд суурилсан мал маллагааны арга технологи, тэжээлийн аюулгүй байдлын үйлдвэрлэл, стандартын талаар онолын сургалт болон Шилийн гол аймгийн сүү цагаан идээ, мах махан бүтээгдэхүүн боловсруулах арга технологи, сав баглаа боодлын үйлдвэрүүдтэй танилцаж практик туршлага судласан.<br>-Явуулын оффис, сумын мал-дын зөвлөгөөнөөр нийт 10 суманд ажиллаж 900 гаруй малчдад төрийн үйлчилгээг хүргэж мэдээлэл өгсөн. |
| 14 | Бэлчээр усжуулалтын хоёрдугаар аяны хүрээнд инженерийн хийцтэй худаг шинээр гаргах | Хувь | 66 | ХХААГ | 100 | Улсын төсөв -61.9 сая төг, ОНХСангийн төсөв 1.149.5 сая төг, бусад эх үүсвэр 1.5 тэрбум төгрөг | Улсын төсөв, ОНХС, Бусад эх үүсвэр | Бэлчээр усжуулалтын хоёрдугаар аяныг 2025 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж, Улсын төсвийн 61.9 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар Баяндалай, Хүрмэн сумдад инженерийн хийцтэй 2 худгийг Эрний эхэн ХХК, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 1076,0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар 15 суманд инженерийн хийцтэй 32 худгийг "Усч шонхор", "Хишиг юниверс" ХХК-иудтай, сумдын орон нутгийн хөгжлийн сан болон төсөл хөтөлбөрийн 1.5 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтаар 63 инженерийн хийцтэй худгийг шинээр гаргаж ашиглалтад оруулсан. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | Балчаар усжуулалтын хоёрдугаар ааны хүрээнд инженерийн хийцтэй хуучин худгийг засварлаж, тоноглох | Хувь | 20 | ХХААГ | 100 | ОНХСангийн 220.4 сая төгрөг, бусад эх үүсвэр 870.2 сая төгрөг | ОНХС, Бусад эх үүсвэр | Балчаар усжуулалтын хоёрдугаар аяныг 2025 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн 220.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 9 сумын бэлчээрт 13 инженерийн хийцтэй худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргөх төхөөрөмжөөр тоноглох ажлыг "Ундарга Өмнөговь" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлж ашиглалтад хүлээн авсан. Сумдын орон нутгийн хөгжлийн сан болон төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар 26 худагт нарны эрчим хүчээр ажилладаг ус өргүүрийг суурилуулсан. 28 худгийг сэргээн засварласан. |
| 16 | Хүнс, хөдөө аж ахуйн салбарын уламжлалт арга хэмжээнүүд болон салбарт ажиллагсдад зориулсан сургалт арга хэмжээнүүдийг зохион байгуулах | Тоо | 7 | ХХААГ | 100 | 175.6 | ОНТ | 1. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн салбарын нэгдсэн зөвлөгөөн, семинарийг 2025 оны 04 сарын 14, 15-ны өдрүүдэд Даланзадгад суманд зохион байгуулсан. Тус зөвлөгөөнд Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газрын эмч мэргэжилтнүүд, 15 сумын мал эмнэлэг, хөдөө аж ахуйн салбарын албан хаагчид ирж оролцсон. /ХХААГ 6,230,000, Мал эмнэлгийн газар 9,330,000 төгрөг/<br>2. "Ингэний айрагны баяр-2025" үзэсгэлэн худалдааг 2025 оны 02 дугаар сарын 14-16-ний өдрүүдэд 16 дахь удаагаа зохион байгуулсан. Арга хэмжээнд 15 сумын 180 орчим иргэн, аж ахуй нэгж сүү сүүн бүтээгдэхүүн, гар урлал, газар тариалангийн чиглэлээр оролцож 245,0 сая гаруй төгрөгийн борлуулалт хийгдсэн байна. /16,255,000 төгрөг/<br>3. Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Сайханы сарлаг-2025" сарлагийн баярын арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Говь гурван сайхан уулын Ёлын амны Үнэгт гадэг газар зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд 15 ерх 611 сарлаг, 101 тугалтай оролцохын зэрэгцээ дотоодын 5400 гаруй иргэд, гадаадын 27 жуулчин зорин очиж сарлагийн баярын хүрээнд зохион байгуулсан уралдаан тэмцээнд оролцож, үзэж сонирхсон байна. /44,735,650 төгрөг/<br>4. "Говь фестиваль-2025" үзэсгэлэн худалдааг 2025 оны 09 дүгээр сарын 19, 20-ны өдрүүдэд 21 дахь жилдээ Даланзадгад хотноо зохион байгуулагдлаа. Арга хэмжээнд 15 сумын 200 орчим иргэн, аж ахуй нэгж сүү сүүн бүтээгдэхүүн, гар урлал, газар тариалангийн чиглэлээр оролцож 200,0 сая гаруй төгрөгийн борлуулалт хийсэн байна. /18,700,000 төгрөг/<br>5."Шилмэл мал-2025" арга хэмжээг 09 сарын 19-ний өдөр зохион байгуулж аймгийн хэмжээнд 9 сумын 120 өрх 160 гаруй шилмэл хээлтүүлэгч, шилмэл хээлтэгч, дуудлага худалдаанд оролцуулах малтай оролцсон. Уг арга хэмжээний хүрээнд шилмэл азарга, шилмэл гүү, шилмэл бух, шилмэл үнээ, шилмэл хуц, шилмэл эм хонь, шилмэл ухна, шилмэл эм ямааны төрлөөр шалгаруулж 1-4 байр эзлүүлэн шагнаж урамшуулсан. /25,260,000 төгрөг/<br>6. Говийн болон зүүн бүсийн аймгуудын аварга тогооч, зөөгч шалгаруулах "Буурч цом-2025 " ажил мэргэжлийн ур чадварын уралдааны 2025 оны 9 дүгээр сарын 18, 19-ний өдрүүдэд Даланзадгад хотноо амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тус арга хэмжээнд 5 аймгийн 150 гаруй тогооч ур чадвараараа өрсөлдөж мэдлэгээ сорьсон арга хэмжээ болсон. /55,100,000 төгрөг/ |
| 17 | Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх | Хувь | 100 | ХХААГ | 100 | ОНТөсөв 1,632.9 сая төгрөг | ОНТ | 1. Орон нутгийн 2024-2025 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд аймаг, сумдын аюулгүй нөөцөд өвс, тэжээл нийлүүлэх ажлын хүрээнд Баян-Овоо, Манлай, ханбогд, Ханхонгор, Цогт-Овоо, Цогтцэций, сумдад болон аймгийн нөөцөд 280 тонн /11200 шуудай/ хивэгэн тэжээл нийлүүлэх /Багц-4/ ажлыг "Сансиунс" ХХК-тай 318,560,000 төгрөгийн дүн бүхий гэрээ байгуулан гүйцэтгүүлж ашиглагч байгууллагуудад хүлээлгэн өгсөн.<br>2. Сумдын аюулгүй нөөцөд 714,4 сая төгрөгийн өвс, тэжээл бэлтгэх ажлыг Баяндалай, Баян-Овоо, Гурвантэс, Мандал-Овоо, Манлай, Ноён, Сэврэй, Ханбогд, Цогт-Овоо, Цогтцэций, Даланзадгад сумдад эрх шилжүүлэн гүйцэтгүүлсэн.<br>3. Орон нутгийн 2025 оны хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд орон нутгийн төсвийн 200,0 сая төгрөгийн хяналтын төсөв бүхий аймаг сумдын аюулгүйн нөөцөд өвс бэлтгэх ажлыг Онцгой байдлын газарт эрх шилжүүлэн гүйцэтгүүлсэн.<br>4. Орон нутгийн 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлын хүрээнд орон нутгийн төсвийн 400,0 сая төгрөгийн хяналтын төсөв бүхий аймгийн өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд өвс, тэжээл бэлтгэх ажлыг Онцгой байдлын газарт эрх шилжүүлэн гүйцэтгүүлсэн. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 18 | "Нутгийн үйлдвэрлэгч" хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах | Хувь | 90 | ХХААГ | 100 | | | Үйлдвэрийн бүсийн төлөвлөлт, дэд бүтцийг сайжруулж, бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг хөгжүүлэх, бизнесийн өрсөлдөх чадвар, зах зээлийн боломжийг нэмэгдүүлэх, санхүүгийн дэмжлэг, төсөл хөтөлбөрөөр тогтвортой хөгжлийг хангах зорилготой "Нутгийн үйлдвэрлэгч" хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 7/05 тогтоолоор батлуулан ажиллаж байна. Нутгийн үйлдвэрлэгч хөтөлбөрийн хүрээнд:<br>1. Орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж 50 аж ахуйн нэгжийг 8.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамруулж, 220 ажлын байр хадгалагдаж, 249 ажлын байр шинээр бий болсон.<br>2. Төсөл сонгон шалгаруулалт зарлагдсантай холбоотой журмын танилцуулга болон бизнес төсөл боловсруулах талаар танхимын сургалтыг 2025 оны 03 сарын 21-ний өдөр зохион байгуулж 250 иргэн, аж ахуйн нэгж хамруулан зохион байгуулсан.<br>3. "ЗӨВЛӨЕ, ТУСАЛЪЯ"" нэг цэгийн үйлчилгээг үзүүлэн, төсөл боловсруулах, хавсралт материал бүрдүүлэх, журмын талаар зөвлөх үйлчилгээг аймгийн 7 байгууллагын 8 хүний бүрэлдэхүүнтэй үзүүлэн 300 гаруй иргэн, аж ахуйн нэгжид хүрч ажилллалаа.<br>Орон нутгийн болон улс бусийн хэмжээнд зохион байгуулагдсан 3 үзэсгэлэн худалдаанд орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний оролцуулсан.<br>4. ӨМӨЗО-ы Хөх хотноо "Монгол Хятадын V Экспо-2025" арга хэмжээнд орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчилах, худалдан борлуулах үзэсгэлэн, арга хэмжээнд Даланзадгад, Ханбогд сумын 6 аж ахуй нэгжийн 6 төлөөлөл, төрийн албаны 2 төлөөлийг тус тус оролцуулж үндэсний хувцас, гоо сайхан, элсэн урлал, даавсан урлал зэрэг нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг худалдан 20,000,000 төгрөгийн борлуулалт хийгдсэн.<br>5. Худалдаа, үйлдвэрлэл, ахуйн үйлчилгээ эрхлэгчид, хоршооны төлөөллүүдтэй "Бага үдийн цай" уулзалт арга хэмжээг зохион байгуулж, тэдэнд тулгамдсан асуудал, цаашид хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг нь сонсож "Нутгийн үйлдвэрлэгч" хөтөлбөрийн зорилт арга хэмжээнд тусган ажилласан. |
| 19 | "Нутгийн үйлдвэрлэгч" хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн бичил болон жижиг, дунд үйлдвэрлэлийг санхүү, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжин өргөжүүлэн хөгжүүлэх, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрт хамруулах | Тоо | 10-аас доошгүй | ХХААГ | 100 | 8,200.0 | Эргэн төлөлтийн 2 тэрбум, ОНТ 4 тэрбум, Улсын төсвийн 2.2 тэрбум | 2025 оны тус төсөл сонгон шалгаруулах ажил 03 сарын 06-ны өдрөөс эхэлсэн ба тус ажил эхэлсэнтэй холбоотой жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх хөнгөлөлттэй зээл хамрагдах хүсэлтэй үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид болон уг хөнгөлөлттэй зээлд хамрагдсан жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн хэлэлцүүлэг уулзалтыг "Өсөлттэй Өмнөговь- ЖДҮ оролцоо" сэдвээр хийж хөнгөлөлттэй зээлд хамрагдах 250 гаруй иргэдэд ЖДҮ-ийн төсөл боловсруулах, бизнесийн тооцооллоо хийхэд гаргадаг нийтлэг алдаанаас үүдэн төсөлд хамрагдаж чадахгүй байгаа тул зөвлөгөө өгч, гарын авлага, төслийн загварыг бэлтгэж хүргэсэн. ЗӨВЛӨЕ ТУСАЛЪЯ нэг цэгийн үйлчилгээг төрийн 5 байгууллага, төрийн бус 2 байгууллагын бүрэлдэхүүнтэй үзүүлж ажилласны үр дүнд 300 гаруй иргэн, аж ахуйн нэгжид Цахим үйлчилгээний 5 төрлийн 540 лавлагаа, Улсын бүртгэлийн хэлтсээс 100 гаруй хуулийн этгээдийг шинээр үүсгэх болон нэмэлт өөрчлөлт оруулахад төрийн үйлчилгээг хүргэсэн байна. Үүний үр дүнд 50 аж ахуйн 8.2 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдаж 220 ажлын байр хадгалагдаж, 249 ажлын байр шинээр бий болсон. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 20 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Хоршооны хөгжлийг дэмжих сангуудын зээлдэгчдийг чадавхжуулах, зээлийн эргэн төлөлтийг нэмэгдүүлэх ажиллах | "1. Хувь, 2. Хувь" | "1. 90 2. 55" | ХХААГ | 93.4 | 63 | ОНТ | "1. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлдэгчдийг чадавхжуулах зорилгоор Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх хөнгөлөлттэй зээлд хамрагдах төсөл хүлээн авах хугацаанд буюу 2025 оны 03 сарын 08-ны өдрөөс 04-р сарын 07-н хүртэлх хугацаанд аж ахуй нэгжүүдэд ""ЗӨВЛӨЕ, ТУСАЛЪЯ"" нэг цэгийн үйлчилгээг үзүүлэн, төсөл боловсруулах, хавсралт материал бүрдүүлэх, журмын талаар зөвлөх үйлчилгээг аймгийн 7 байгууллагын 8 хүний бүрэлдэхүүнтэй үзүүлэн 300 гаруй иргэн, аж ахуйн нэгжид хүрч ажилласан. Төрийн цахим үйлчилгээний 5 төрлийн 540 лавлагаа, Улсын бүртгэлийн халтсаас 100 гаруй хуулийн этгээдийг шинээр үүсгэх болон нэмэлт өөрчлөлт оруулахад төрийн үйлчилгээг хүргэсэн. Төсөл хүлээн авах ажил зарласантай холбоотой журмын танилцуулга болон бизнес төсөл боловсруулах талаар танхимын сургалтыг 2025 оны 03 сарын 21-ний өдөр зохион байгуулж 250 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан.<br>2. Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлд урд жилүүдэд хамрагдсан 101 аж ахуйн нэгжийн 8,932,851,794.39 төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй тооцоо нийлж, зээлийн зөрчлийг арилгах талаар зөвлөгөө өгч ажилласан. Зөрчил үүссэн хоногийн тоо 360 давсан 8 аж ахуйн нэгжийг дараагийн шатанд шилжүүлж, 88 зээлдэгчийн газар дээрх үйл ажиллагааны хяналт хийж 102.1 сая төгрөгийн зөрчлийг арилгаад байна.<br>3. 2025 онд хөнгөлөлттэй зээлд хамрагдсан 50 аж ахуйн нэгжүүдэд гэрээний эрх үүрэг, хариуцлага, зээлийн эргэн төлөлт, хяналт мониторинг, үйл ажиллагааг тогтвортой, үр дүнтэй явуулахад дэмжлэг үзүүлэх, зээлийн зориулалтын хэрэгжилтийг сайжруулах сургалтыг 2 удаа зохион байгуулсан.<br>4. Хоршоо хөгжүүлэх сангийн муу ангиллын 63 зээлдэгчийн 1,233,203,000 зээлийн зөрчлөөс Иргэний хуулийн анхан шатны шүүхэд 8 зээлдэгч,Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт анхан шатны шүүхийн шийдвэр гарсан 12 зээлдэгч, Иргэний хуулийн анхан шатны шүүхээс дараагийн шатанд 3 зээлдэгчийн шийдвэрийг хүргүүлж ажилласан. Шүүгчийн захирамжийн дагуу үлдсэн зээлдэгчидтэй эвлэрүүлэн зуучлах ажлын хүрээнд 246,539,878 төгрөгийн зөрчлийг арилгасан. |
| ДҮН | | | | | 99.65 | | | |

ХЯНАСАН:

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА Ш.БАТ-ЭРДЭНЭ

НЭГТГЭСЭН:

ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Э.АЛТАНТУЯА